

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ САЙД АСАН, ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ  
Ш.ЖАДАМБЫН НЭРЭМЖИТ “МОНГОЛ ЦЭРЭГ - 2018” ПРАКТИК  
БУУДЛАГЫН СПОРТЫН II ТҮВШНИЙ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

**Тэмцээн зохион байгуулах газар, байгууллага, хугацаа:** Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны Сайдын тушаалаар батлагдсан 2018 оны хуваарийн дагуу Төр, цэргийн нэрт зүтгэлтэн, Дэслэгч генерал Ш.Жадамбын нэрэмжит “Монгол цэрэг -2018” практик буудлагын спортын тэмцээнийг 2018 оны 3 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд, 10.00 цагт Монголын Практик Буудлагын Холбооны Төв клубын буудлагын талбайд зохион байгуулна.

Төв клубын байршил: Төв аймаг, Сэргэлэн сум, Тахилтын ам /УБ хотоос Зуунмод сум орох замд 29 дэх км-ын заалтын шонг өнгөрөөд баруун гар тал руугаа салж зүүн урд зүгт 3 км явна/.

**1. Тэмцээний зорилго:**

- Шигшээ багийг бүрдүүлэх сайн тамирчдыг тодруулах
- шигшээ багийг шалгаруулах
- практик буудлагаар хичээллэгч тамирчдын ур чадварыг өсгөх
- спортын тамирчдын залуу халааг бэлтгэх
- практик буудлагын спортыг хөгжүүлэн дэлгэрүүлэх
- Монгол улсын иргэдэд цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэхэд хувь нэмэр болох
- Монгол улсын иргэдэд галт зэвсэгтэй аюулгүй харьцах соёл, дадлыг түгээх
- Монгол улсын иргэдийн дунд биеийн тамир спортыг сурталчилан таниулах
- Албаны галт зэвсэг хэрэглэх алба хаагчдын ур чадвар, мэдлэгийг ахиулахад хувь нэмэр болох

**2. Зохион байгуулах бүрэлдэхүүн:**

Тэмцээний удирдагч: Монголын Практик Буудлагын Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга М.Баярсайхан

Ерөнхий шүүгч: Монголын Практик Буудлагын Холбооны Нарийн бичгийн дарга Ч.Дэлгэр

Шүүгч нар: Монголын Практик Буудлагын Холбооны итгэмжлэгдсэн шүүгч нар

Дэслэгч генерал Ш.Жадамбын нэрэмжит Практик буудлагын тэмцээнийг практик буудлагын спортын дүрмээр явуулна. Энэхүү тэмцээнийг зөвхөн Монголын Практик

Буудлагын Холбооны Төв зөвлөлийн зөвшөөрлөөр явуулах ба практик буудлагын спортын итгэмжлэгдсэн шүүгч нар шүүх эрхтэй.

**Тэмцээнийг зөвшөөрөлгүйгээр зохион байгуулсан тохиолдолд тэмцээний үр дүнг тооцохгүй ба зөвшөөрөгдөөгүй тэмцээнд оролцогчид, үзэгчдийн аюулгүй байдалд Монголын Практик Буудлагын Холбоо хариуцлага хүлээхгүй.**

### **3. Тэмцээний бүртгэл**

- Тэмцээний бүртгэлийг 2018.03.15 өдрийн 18:00 цаг хүртэл хийнэ.
- Нэг байгууллагаас хэдэн ч баг, тамирчин оролцож болно.
- **Тэмцээний өдөр бүртгэл хийгдэхгүй.**
- Бүртгэлийг:
  - o 99063969 /МПБХ-ны Нарийн бичгийн дарга Ч.Дэлгэр/ дугаарын утасаар,
  - o [www.ipsc.mn](http://www.ipsc.mn) цахим хуудсаар тус тус хийнэ.
- Бүртгүүлэхдээ бүртгэлийн хуудасны дагуу мэдээллийг өгнө /удирдамжийн хавсралтаар/

### **4. Тэмцээний нөхцөл**

Тэмцээнд оролцогч нь зарлагдсан хугацаанд багтан бүртгүүлнэ. Тэмцээн дараах 2 төрлөөр явагдана. Дүнг 2 төрөлтийн нийлбэрээр гаргана.

**Гар буу:** 6 дасгалд 6 бүлэг буудагч байна. 1-р бүлэг эхний дасгалыг гүйцэтгэж байх үед бусад 5 бүлэг нь тус бүрийн дасгалыг гүйцэтгээд тухайн бүлгийн бүх буудагч буудаж дууссаны дараа дараагийн дасгалын талбай руу тойргийн журмаар шилжин явна. Үр дүнг тооцохдоо тухайн дасгалд авсан оноог гүйцэтгэсэн хугацаанд хуваана. Хугацааг секундын мянганы нэгжээр нарийвчлан тооцно.

**Карабин:** 6 дасгалд 6 бүлэг буудагч байна. Эхний бүлэг буудагч дасгалыг гүйцэтгэж дуусаад дараагийн дасгал руу шилжин явна. Үр дүнг тооцохдоо тухайн дасгалд авсан оноог гүйцэтгэсэн хугацаанд хуваана. Хугацааг секундын зууны нэгжээр нарийвчлан тооцно.

**Халз буудлага-**буудалтын тоо хязгааргүй (хамгийн багадаа 8 буудлага хийнэ);

Гар буу болон карабины төрлөөр явагдана. Дүнгээр эхний 8 байранд орсон буудагч оролцоно.

**Гар буу, карабины нийлбэр дүнгээр ялагчийг тодруулна.**

Дасгал бүрийг бүртгэгдсэн оролцогч нар ээлж дараагаар гүйцэтгэнэ. Хамгийн өндөр оноо авсан буудагчийг ялагчаар тодруулна.

Буудагч бүрт хувийн онооны хуудас олгогдох ба буудлагын талбайн шүүгчээр авсан оноо, дасгалыг гүйцэтгэсэн хугацааг тэмдэглүүлж гарын үсэг зурна. Дасгал гүйцэтгэх буудагч нь зөвхөн талбайн шүүгчийн командаар зэвсгийг гаргаж цэнэглэнэ. Тэмцээний төрөл бүрт эхний 3 буудагч, 3 багийг /баг 4 гишүүнтэй байна/ шалгаруулна.

Дасгалыг гүйцэтгэх буудагч нь галын шугам дээр талбайн шүүгчийн “зэвсэг цэнэглэж бэлдэнэ үү” командаар зэвсгийг гэр, савнаас гарган цэнэглээд дасгалын заагдсан нөхцөлөөр бэлэн байдалд орно. Дараагийн “бэлэн үү?” командын хариуд буудагч “Бэлэн” гэж хэлэх эсвэл толгой дохих, чимээгүй байдлаар дасгалыг гүйцэтгэхэд бэлэн гэдгийг илтгэнэ. Шүүгч “АНХААР” команд өгч 1-4 секундын дараа дуут дохиогоор дасгалыг эхлэх хугацаа явж,

сүүлчийн буудалтаар хугацаа зогсоно. Дасгал гүйцэтгэсний дараа шүүгчийн “Хэрэв буудаж дууссан бол зэвсгийг шалгаж аюулгүй болгоод харуулна уу” командаар цэнэггүй болгосон зэвсгийг шүүгчид харуулан дараагийн “Хэрэв зэвсгийг шалгасан бол хяналтын буудлага /хуурай буудлага хийж чавхыг буулгана/, Зэвсэг гэрт” командаар буудагч нь аюулгүй байдлыг сахин аюулгүй болгосон зэвсгийг гэр, саванд хийнэ. Шүүгчийн “байг шалга” командаар бай руу явна. Шүүгч нар байг шалгаж алдаа оноог тэмдэглэнэ. Буудагч өөрийн онооны хуудас үнэн зөв бөглөгдсөн эсэхийг нягтлаад гарын үсгээр баталгаажуулна. Онооны хуудсыг онооны шүүгч хураан авч цахим хэлбэрээр дүнг гаргана.

Үр дүнг тооцохдоо тухайн дасгалд авсан оноог гүйцэтгэсэн хугацаанд хуваана. Хугацааг секундын мянганы нэгжээр нарийвчлан тооцно.

## **5. Тэмцээнд хэрэглэх галт зэвсэг, сум, хэрэгсэл**

### **1. Гар буу**

9 мм-с дээш калибрийн бүх төрлийн гар буунууд.

Онооны нийт буудалт: **110**

### **2. Карабин**

5,45 мм-с дээш калибрийн бүх төрлийн хагас автомат.

Онооны нийт буудалт: **104**

**Сум: Шатаагч болон гэрэлтэгч, хуяг нэвтлэгч сум ашиглахыг хориглоно**

Аливаа сум хэрэгслийг Шүүгч аюултай гэж үзвэл тэмцээнд ашиглахыг зөвшөөрөхгүй. Гар бууг суганд зүүхийг хориглоно. Буудагч нар гар бууг зөвхөн ташаанд зүүнэ. Гар буу гэрт байх үед гохны хэсэг бүрэн далдлагдсан байна. Гар бууны гэр бүс нь өмдний 3-аас доошгүй гогцоонд найдвартай бэхлэгдсэн байна. Гэрт хийсэн гар бууны гол төмрийн чиглэлийн тусгал буудагчийн хөлнөөс 1 метрээс ихгүй байна.

## **6. Тэмцээнд оролцогч**

Тэмцээнд оролцогч нь Монголын Практик Буудлагын Холбооны гишүүн, буудлагын спорт холбоод, өмнө нь МПБХ-оос зохион байгуулж байсан тэмцээнд оролцож байсан болон сургалтад хамрагдсан буудагч, төрийн тусгай албадын алба хаагч нар байна.

**Практик буудлагын спортын тэмцээнд оролцож байгаагүй, сургалтад хамрагдаагүй албаны болон спортын буудагч нарыг тэмцээнд оролцуулахгүй.**

Тэмцээний 1 төрөлд 5-аас доошгүй буудагч бүртгэгдсэн тохиолдолд тухайн төрлийг эхлүүлнэ. 18 буюу түүнээс дээш насны эрэгтэй, эмэгтэй буудагч нар оролцоно.

## **7. Аюулгүй ажиллагааны шаардлага**

Тэмцээнийг явуулахад аюулгүй ажиллагааны журмыг чанд сахина. Оролцогч тамирчид ба үзэгчдээс аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг биелүүлээгүй тохиолдолд тэмцээний талбайгаас гаргана.

- 1. Зэвсэгтэй үргэлж цэнэгтэй мэт харьцана.**
- 2. Зэвсгийг үргэлж аюулгүй зүгт чиглүүлнэ.**
- 3. Буудахын өмнө байны наана болон цаана юу байгааг үргэлж хянана.**
- 4. Зэвсгийг бай руу чиглүүлэхээс бусад тохиолдолд гох дээр хурууг тавихгүй.**

Буудлагын талбайд байгаа бүх буудагч нарын гар буу зэвсгийн гэрт, карабин болон винтов төрлийн зэвсгүүд зориулалтын хайрцаг, тавиурт магазин угсраагүй, цэнэггүй байдалтай байна. Үүнд буудлагын талбайн харуул хамгаалалтын ажилтан хамаарахгүй. Тэмцээнд оролцогч бүр өөрийн бие болон сэтгэл зүйн байдлыг бүрэн хянах ёстой.

Тамирчид болон бусад оролцогчид мансууруулах болон сэтгэцэд нөөлөөлөх бусад /архи, тамхи г.м/ зүйлсийг хэрэглэхийг хатуу хориглоно. Эмчилгээний зорилгоор ашиглаж байгаа бол эмчийн бичгээр өгсөн баталгаанаас гадна тэдгээр нь хариу үйлдэл, сэтгэц болон биеэ авч явах байдалд нь нөлөө үзүүлэхгүй байх шаардлагатай.

Буудлагын талбайд байгаа хүн бүр хамгаалалтын нүдний шил, чихэвчийг байнга зүүнэ. Шүүгчийн зөвшөөрөлгүйгээр зэвсгийг гэрнээс гаргах, магазин угсрахыг хориглоно. Зэвсэгтэй харьцах бүх үйлдэл нь зөвхөн шүүгчийн командаар галын шугам дээр эсвэл “АЮУЛГҮЙН БҮС” дээр хийгдэнэ. “АЮУЛГҮЙН БҮС” гэдэг нь тухайн буудлагын талбайд аюулгүй зүгт хуурай дасгал хийх, зэвсгийг задалж угсрах, тослох, засвар үйлчилгээ хийх зэрэг буудахаас бусад үйлдэл хийхийг зөвшөөрсөн газрыг хэлнэ.

“АЮУЛГҮЙН БҮС”-д хориглох зүйл

- Сум бүхий магазинд гар хүрэх, сум болон түүнтэй ижил төстэй загварын сум хэрэгслийг гарт барих, зэвсгэнд сумтай магазин угсрахыг хориглоно.

Буудагч галын шугамнаас бусад газарт зэвсгийг санамсаргүй унагаасан тохиолдолд тэмцээнээс хасагдах арга хэмжээ авагдахгүй ба зэвсгийг газраас өөрөө авахыг хориглоно. Талбайн шүүгч унасан зэвсгийг газраас авахдаа оролцогч болон үзэгчдийг холдуулж, зэвсгийн амыг аюулгүй зүгт харуулан авна.

Магазиныг буудлагын талбайн аль ч хэсэгт сумлаж болно. Ажил үүргийн шаардлагаар биедээ зэвсэг авч явах эрх бүхий зарим төрийн тусгай албадын буудагч нар буудлагын талбай руу орохоос өмнө зэвсгээ цэнэггүй болгож, гарахдаа цэнэглэн гарч болно.

## **8. Хувцас хэрэглэл**

Тэмцээний хувцас хэрэглэл МПБХ-ны дүрмийн дагуу байна. Иргэний болон спорт холбоодын буудагч нар өнгөлөн далдлалтын болон цэргийн хувцас өмсөхийг хориглоно. Хууль сахиулах болон цэргийн байгууллагын буудагч нар суганаас бусад байрлалд бэхлэх албаны зориулалт бүхий зэвсгийн гэрүүдийг хэрэглэхийг зөвшөөрнө. Мөн нүдний хамгаалалтын шил, чихэвчийг заавал зүүсэн байна.

## **9. Байнууд**

Практик Буудлагын Спортын тэмцээнд 20 ба 30 сантиметрийн диаметртэй төмөр бай (гонг), цаасан байнуудыг ашиглана. Цаасан байг байршуулах дээд өндөр 1,5 м.

## **10. Тэмцээний хөтөлбөр**

**2018 оны 3-р сарын 17:**

10:00-13:00 – карабины тэмцээн хувийн болон багийн дүнгээр явагдана

13:00-13:30 – тэмцээний нээлт

13:30-14:00 – цайны завсарлага

14:00-16:30 – карабины тэмцээн

**2018 оны 3-р сарын 18:**

10:00-13:00 – гар бууны тэмцээн

13:00-13:30 – цайны завсарлага

13:30-15:30 – гар бууны тэмцээн

15:30-16:30 – онооны тулгалт, халз буудлагын тэмцээн

16:30-17:00 – шагнал гардуулах ёслол, тэмцээний хаалтын ажиллагаа

**11. Шагнал, урамшуулал**

Багийн болон хувийн дүнгээр эхний 3 байрыг шалгаруулна.

Хувийн дүнгээр эхний 3 байрын шагнал: Медаль, батламж, үнэ бүхий зүйлс

Багийн дүнгээр эхний 3 байрын шагнал: Медаль, батламж

Халз буудлага: үнэ бүхий зүйл

**12. Тэмцээнээс хасах.**

-Дасгалыг гүйцэтгэх явцад буудлагын аюулгүйн өнцөг алдсан

-Дасгалыг гүйцэтгэх шилжилт хөдөлгөөний үед гох дээр хуруу тавьсан

-Спортын бус байдлаар биеэ авч явах, хууран мэхлэх, спортын дүрмийн бус байдлаар давамгай байдал олж авах гэсэн оролдлого, үйлдэл гаргах, зүй бус үг хэллэг хэлэх, тэмцээн зохион байгуулагчдын зүгээс тавьсан ухамсарт шаардлагыг биелүүлээгүй г.м тохиолдолд

-Практик буудлагын спортын дүрэмд заагдсан бусад нөхцөлүүд

-Галын шугамнаас гадна зэвсгэнд магазиныг угсарсан

-Галын шугамнаас бусад газар зэвсгийн хошууг аюултай зүгт чиглүүлсэн тохиолдолд тэмцээнээс хасна.

Хянасан: МПБХ-ны

Ерөнхий нарийн бичгийн дарга:


М.Баярсайхан

Боловсруулсан: МПБХ-ны ажилтан:

Д.Энхбаатар


# ТЭМЦЭЭНИЙ ДАСГАЛУУД

## Нэг. Карабины дасгалууд




|                      |                                                                                                        |
|----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------|
| Targets:             | 2 IPSC Popper, 10 IPSC Targets, 3 No-Shoot, 2 IPSC Metal plates                                        |
| Rounds to be scored: | 24                                                                                                     |
| Maximum points:      | 120                                                                                                    |
| Start position:      | Stands at marks, facing downrange                                                                      |
| Gun condition:       | Gun is loaded, holstered                                                                               |
| Time starts:         | On audible signal,                                                                                     |
| Procedure:           | Upon signal, engage all targets. P1 activates T1 and P2 activates T2 which will remain visible at rest |
| Safety angles:       | 90 degrees left/right and top of the backstop                                                          |

# КАРАБИНЫ ДАСГАЛ




|                      |                                                                                                                           |
|----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Targets:             | 2 IPSC Popper, 4 IPSC Targets, 2 IPSC Metal Plates, 1No-shoot                                                             |
| Rounds to be scored: | 12                                                                                                                        |
| Maximum points:      | 60                                                                                                                        |
| Start position:      | Sitting at chair, hands on knees, gun loaded on desk, muzzle facing downrange.                                            |
| Gun condition:       | Gun is loaded on desk                                                                                                     |
| Start, stop:         | Audible signal                                                                                                            |
| Procedure:           | After start signal shoot all the targets from designated area. CP1 or CP2 activate T4, which will remain visible at rest. |
| Safety angles:       | 90 degrees left/right and top of the backstop                                                                             |

# КАРАБИНЫ ДАСГАЛ




|                      |                                                                                                                          |
|----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Targets:             | 2 IPSC Popper, 5 IPSC Targets                                                                                            |
| Rounds to be scored: | 12                                                                                                                       |
| Maximum points:      | 60                                                                                                                       |
| Start position:      | Standing at point A , facing down range                                                                                  |
| Gun condition:       | Gun is loaded and holstered                                                                                              |
| Start:               | Audible signal                                                                                                           |
| Procedure:           | After start signal shoot all the targets from designated area. IP1 or IP2 activate T3 which will remain visible at rest. |
| Safety angles:       | 90 degrees left/right and top of the backstop                                                                            |

# КАРАБИНЫ ДАСГАЛ




|                      |                                                               |
|----------------------|---------------------------------------------------------------|
| Targets:             | 2 IPSC Popper, 4 IPSC Targets, 1 No-shoot, 2 IPSC Metal plate |
| Rounds to be scored: | 12                                                            |
| Maximum points:      | 60                                                            |
| Start position:      | Standing at marks, facing downrange                           |
| Gun condition:       | Gun is loaded and holstered                                   |
| Time starts:         | On audible signal,                                            |
| Procedure:           | Upon signal, engage all targets.                              |
| Safety angles:       | 90 degrees left/right and top of the backstop                 |

# КАРАБИНЫ ДАСГАЛ



|                      |                                                                                                                    |
|----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Targets:             | 2 IPSC Popper, 4 IPSC Targets, 1 No-shoot, 2 IPSC metal plates                                                     |
| Rounds to be scored: | 12                                                                                                                 |
| Maximum points:      | 60                                                                                                                 |
| Start position:      | Standing at point A, facing downrange                                                                              |
| Gun condition:       | Gun is loaded and holstered                                                                                        |
| Start:               | Audible signal                                                                                                     |
| Procedure:           | After start signal shoot all the targets from designated area. IP1 activate T3, which will remain visible at rest. |
| Safety angles:       | 90 degrees left/right and top of the backstop                                                                      |


# КАРАБИНЫ ДАСГАЛ



|                      |                                                                                            |
|----------------------|--------------------------------------------------------------------------------------------|
| Targets:             | 6 IPSC Popper, 13 IPSC Targets, 4 No-Shoot,                                                |
| Rounds to be scored: | 32                                                                                         |
| Maximum points:      | 160                                                                                        |
| Start position:      | Stands at marks, facing downrange                                                          |
| Gun condition:       | Gun is loaded, holstered                                                                   |
| Time starts:         | On audible signal,                                                                         |
| Procedure:           | Upon signal, engage all targets. IP1 activate T1 and T2 which will remain visible at rest. |
| Safety angles:       | 90 degrees left/right and top of the backstop                                              |


## Хоёр. Гар бууны дасгалууд

ГАР БУУНЫ ДАСГАЛ




|                      |                                                                                                                                       |
|----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Targets:             | 2 IPSC Popper, 5 IPSC Targets, 1 No-shoot                                                                                             |
| Rounds to be scored: | 12                                                                                                                                    |
| Maximum points:      | 60                                                                                                                                    |
| Start position:      | Strong hand on X's, facing downrange                                                                                                  |
| Gun condition:       | Gun is loaded and holstered                                                                                                           |
| Start:               | Audible signal                                                                                                                        |
| Procedure:           | After start signal shoot all the targets from designated area. Popper IP2 activate swing target T4 which will remain visible at rest. |
| Safety angles:       | 90 degrees left/right and top of the backstop                                                                                         |

# ГАР БУУНЫ ДАСГАЛ




|                      |                                                                |
|----------------------|----------------------------------------------------------------|
| Targets:             | 4 IPSC Popper, 9 IPSC Targets, 2 No-shoot, 1IPSC Metal Plate   |
| Rounds to be scored: | 23                                                             |
| Maximum points:      | 115                                                            |
| Start position:      | Standing at marks, facing downrange                            |
| Gun condition:       | Gun is loaded and holstered                                    |
| Time starts:         | On audible signal,                                             |
| Procedure:           | After start signal shoot all the targets from designated area. |
| Safety angles:       | 90 degrees left/right and top of the backstop                  |

# ГАР БУУНЫ ДАСГАЛ





|                      |                                                                                                                                  |
|----------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Targets:             | 13 IPSC Targets, 4 No-Shoot, 4 IPSC Popper, 2 IPSC Metal Plate                                                                   |
| Rounds to be scored: | 32                                                                                                                               |
| Maximum points:      | 160                                                                                                                              |
| Start position:      | Standing at point A , facing down range                                                                                          |
| Gun condition:       | Gun is loaded and holstered                                                                                                      |
| Start, stop:         | Audible signal                                                                                                                   |
| Procedure:           | After start signal shoot all the targets from designated area. . IP1 activate T5, IP2 activate T11 which remains visible at rest |
| Safety angles:       | 90 degrees left/right and top of the backstop                                                                                    |



|                      |                                                                                                              |
|----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------|
| Targets:             | 3 IPSC Popper, 8 IPSC Targets, 1 No-shoot                                                                    |
| Rounds to be scored: | 19                                                                                                           |
| Maximum points:      | 95                                                                                                           |
| Start position:      | Sitting at chair, facing downrange                                                                           |
| Gun condition:       | Gun is unloaded flat at the table with all mags,                                                             |
| Time starts:         | On audible signal,                                                                                           |
| Procedure:           | Upon signal, engage all targets. IP2 activate T1 and IP3 activate T4 which they will remain visible at rest. |
| Safety angles:       | 90 degrees left/right and top of the backstop                                                                |

# ГАР БУУНЫ ДАСТАЛ



- Targets: 2 IPSC Popper, 5 IPSC Targets,  
 Rounds to be scored: 12  
 Maximum points: 60  
 Start position: Standing at point A, facing downrange  
 Gun condition: Gun is loaded and holstered  
 Time starts: On audible signal,  
 Procedure: After start signal shoot all the targets from designated area. IP1 activate swing target T1 and T2. The moving IPSC Target T1 and T2 remains visible at rest  
 Safety angles: 90 degrees left/right and top of the backstop